

ЗӨӨВРИЙН ЦӨМИЙН ХЭМЖҮҮРИЙН АШИГЛАХАД МӨРДӨХ ЦАЦРАГИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ДҮРЭМ

Нэг. Ерөнхий зүйл

1.1 Зорилго

1.1.1 Зөөврийн цөмийн хэмжүүр ашиглан үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгж, байгууллагуудад цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлыг хангуулан цацрагтай ажиллагчдыг үндэслэлгүй аливаа шарлагад өртүүлэхгүй байх, цацрагийн болзошгүй осол үүсэхээс урьдчилан сэргийлэхэд энэхүү дүрмийн зорилго оршино.

1.1.2 Нягт, чийг хэмжих зориулалтын зөөврийн цөмийн хэмжүүр ашиглан үйл ажиллагаа явуулж буй байгууллагууд нь Цөмийн энергийн тухай хууль, Цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааны үндсэн дүрэм, Цацрагийн аюулгүйн норм, Цацрагтай холбогдолтой үйл ажиллагаа эрхэлж буй байгууллагын цацрагийн аюулгүй албаны дүрэм, Цацрагийн үүсгүүрийн аюулгүй байдлыг хангах дүрэм болон энэхүү дүрмийг мөрдлөг болгоно.

1.1.1. Хамрах хүрээ

Энэхүү дүрмийн шаардлагыг цацрагийн үүсгүүр бүхий чийг, нягт хэмжих зориулалттай зөөврийн цөмийн хэмжүүр ашиглан үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгж, байгууллага, ажилтан, албан хаагч заавал мөрдөнө.

Хоёр. Үндсэн шаардлагууд

2.1 Цацрагийн үүсгүүр ашиглах үйл ажиллагаа нь цацрагийн аюулгүй ажиллагааны холбогдох норм, стандарт, дүрмийн дагуу хор уршиг, цацрагийн болзошгүй ослоос сэргийлсэн байна.

2.2 Цацрагийн үүсгүүр ашиглах үйл ажиллагаа нь тодорхой, илүү ойлгомжтой байх ба дараах нөхцөлийг агуулсан байна.

2.2.1 Цацрагийн хяналт ажилтан нь зөөврийн цөмийн хэмжүүрийн эргэн тойронд цацрагийн хяналтын хэмжилт хийх;

2.2.2 Зөөврийн цөмийн хэмжүүрийн ашиглалтын зааврын дагуу аюулгүй ажиллах;

2.2.3 Цацрагийн хэмжилт хийх болон бусад холбогдох арчих сорилт, хэмжилтийг хийж, үр дүнг бүртгэлжүүлэн хадгалах;

2.2.4 Хамгаалалтын гэр бүхий үүсгүүрт дараах биет хамгаалалт болон аюулгүй байдлыг хангана.

- Хяналтын төхөөрөмж (камер);

- Хувийн хяналтын хэмжилтийн багаж;

- Хувийн хяналтын дозиметр;

- Хөдөлмөр хамгаалалтын хувцас;

- Хадгалалтын явцад хянах зориулалт бүхий дозиметр;

- Хадгалж буй газрын ойр орчныг хянах зэрэг болно.

2.2.5 Цацрагтай ажиллагч болон хүн амыг цацрагийн шарлагын тунг хамгийн доод хэмжээнд байлгана.

2.2.6 Цацрагийн болзошгүй ослын төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллана.

2.2.7 Шаардлагатай зөвшөөрлийг эрх бүхий холбогдох хяналтын байгууллагаас авна.

2.2.8 Эрх бүхий холбогдох хяналтын байгууллагын шаардлага, тусгай зааврыг биелүүлж ажиллана.

2.2.9 Холбогдох хууль, дүрэм, стандартын дагуу аюулгүй хадгалах, тээвэрлэх үйл

ажиллагааг явуулна.

2.2.10 Цөмийн хэмжүүрийн засвар үйлчилгээ болон багаж баталгаажуулалтыг холбогдох хууль, дүрэм, стандартын дагуу хийж гүйцэтгэнэ.

2.2.11 Цөмийн хэмжүүрийг ашиглах явцдаа заавал цацрагийн аюулгүйн тэмдгийг холбогдох дүрэм, стандарт, зааврын дагуу байршуулна.

2.2.12 Мөн цөмийн хэмжүүрийн ажиллагаатай гарах аливаа тохиолдолд дараах холбогдох эрх албан хаагчдын утас, хаягийг заавал байршуулсан байна. Үүнд:

- Цацрагийн хяналтын ажилтан;
- Эрх холбогдох хяналтын байгууллага болон түүний эрх бүхий ажилтан;
- Бусад холбогдох эрх бүхий ажилтан;
- Холбогдох Онцгой байдлын газар;

2.3 Зөөврийн цөмийн хэмжүүрийн ашиглалтын үед өгөх зааварчилгаанд дараах зүйлийг багтаана.

2.3.1 Хамгаалалтын гэрээс үүсгүүрийг гаргахаас өмнө 3 метрээс дотогш зайд шаардлагагүй ажилтан болон бусад хүмүүс байлгахыг хориглоно.

2.3.2 Цацрагтай ажиллагчдыг аль болох шарлагын тунг зохистой хэмжээний хамгийн доод түвшинд байлгана.

2.3.3 Зөөврийн цөмийн хэмжүүрийн ашиглалтын явцад тухайн бүсэд хяналтын бүс тогтооно.

2.3.4 Зөөврийн цөмийн хэмжүүрийг ашиглаагүй тохиолдолд цоожтой байлгах ёстой.

2.3.5 Хамгаалалтын гэр бүхий цацрагийн үүсгүүрийг хэмжилт хийх, засвар үйлчилгээ (үүсгүүрийн савааг цэвэрлэх гэх мэт) хийхээс өөр тохиолдолд хөдөлгөхийг хориглоно.

2.3.6 Зөөврийн цөмийн хэмжүүрийг ашиглан хэмжилт хийхээс бусад тохиолдолд аль болох хол зайд байлгах шаардлагатай.

2.3.7 Зөөврийн цөмийн хэмжүүрийг ашиглан хэмжилт хийхдээ хувийн хамгаалах хэрэгсэл, дозиметрээр бүрэн хангагдсан байна.

2.3.8 Тээврийн хэрэгсэл, машин механизмын ойролцоо зөөврийн цөмийн хэмжүүрийг байрлуулахыг хориглоно.

Гурав. Нийлүүлэгчийн үүрэг хариуцлага

3.1 Суурин цөмийн хэмжүүрийг нийлүүлэгч нь цацрагийн хамгаалалтын хөтөлбөртэй байна.

3.2 Цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааны хөтөлбөрийг жил бүр шалгаж, сайжруулан шинэчилж байх ёстой.

3.3 Эрх бүхий холбогдох хяналтын байгууллагын зөвшөөрөлтэй байна.

3.4 Эрх бүхий холбогдох хяналтын байгууллагын хяналтад зөөврийн цөмийн хэмжүүрийг нийлүүлсэн байна.

3.5 Цацрагийн хяналтын ажилтанг томилсон байна.

3.6 Нийлүүлэгч нь цөмийн хэмжүүрийн ашиглалтын хугацаанд хамгийн багадаа нэг удаа хэмжүүртэй холбоотой заавар, зааварчилгаа, зөвлөмжийг өгнө.

3.7 Нэг болон түүнээс дээш цацрагийн үүсгүүр бүхий зөөврийн цөмийн хэмжүүрийн төрөл, загвар нь зөв зохион бүтээгдсэн байна.

3.8 Зөөврийн цөмийн хэмжүүр нь цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааны болон түүний ажиллагаа, техникийн үзүүлэлт стандартын шаардлагыг хангасан байна.

3.9 Зөөврийн цөмийн хэмжүүрийн удирдлагын самбар, дэлгэц нь ойлгомжтой байх ба тохирох хэл дээр зохион бүтээгдсэн байна.

3.10 Ажиллуулах болон засварлах заавар, цацрагийн аюул, үзүүлэлтүүд, хамгаалалт, аюулгүй ажиллагааны зааварчилгаа нь ойлгомжтой, тохирох хэл дээр бичигдсэн байна.

3.11 Цацрагийн хамгаалалтын материалаар хамгаалалагдсан байна.

3.12 Зөөврийн цөмийн хэмжүүрийг нийлүүлэгч нь дараах бүртгэлийг хөтөлсөн байна. Үүнд:

- Үйлдвэрлэсэн болон нийлүүлсэн зөөврийн цөмийн хэмжүүрийн тоо бүртгэл;

- Үйлдвэрлэсэн болон нийлүүлсэн цацрагийн үүсгүүрийн тоо бүртгэл;

3.13 Зөөврийн цөмийн хэмжүүрийг нийлүүлэгч нь дараах тохиолдолд л цөмийн хэмжүүрийг нийлүүлнэ. Үүнд:

- Хүлээн авагч болон эцсийн хэрэглэгч нь эрх бүхий холбогдох хяналтын байгууллагаас цацрагийн үүсгүүртэй холбоотой үйл ажиллагаа явуулах эрхийн зөвшөөрөл авсан байх;

3.14 Хүлээн авагч болон хэрэглэгч нь цөмийн хэмжүүр бүхий цацрагийн үүсгүүрийг ашиглалтаас гаргах талаар нийлүүлэгчтэй дараах нөхцөлийг тохиролцоно. Үүнд:

- Зөөврийн цөмийн хэмжүүрийг импортлогч, нийлүүлэгчид буцаах;
- Тусгай зориулалтын байранд төвлөрүүлэн хадгалах, хаягдлын менежментийг гүйцэтгэх байгууламжид шилжүүлэх;
- Цөмийн хэмжүүрийн төрөл, хэрэглэх зориулалт, аргачлал нь тодорхой бус, эрх бүхий холбогдох хяналтын байгууллагаар зөвшөөрөгдөөгүй бол тэдгээрийг нийлүүлэхийг хориглох;

3.15 Эрх бүхий холбогдох хяналтын байгууллагаас тусгай зөвшөөрөл авахдаа цөмийн хэмжүүрийн төрөл, зориулалт, хийц загварын талаар дараах нэмэлт материалуудыг бүрдүүлэн өгнө. Үүнд:

- Цацрагийн үүсгүүрийн байрлал, түүний зам, цацрагаас хамгаалах гэрийн техникийн үзүүлэлт;
- Зөөврийн цөмийн хэмжүүр, түүний бүрэлдэхүүн хэсгийн схем зураг;
- Түүнийг угсарч, суурилуулахад хэрэглэгдэх холбогдох гарын авлага, материал;
- Цацрагийн үүсгүүрийн хяналтын систем, үүсгүүрийн хаалт, хамгаалалт, тооцоо, туршилтын дүн;
- Зөөврийн цөмийн хэмжүүрийн аюулгүй ажиллагааны систем, түгжээний мэдээлэл;
- Зөөврийн цөмийн хэмжүүрийн гадаргаас 0.05м болон 1м зайд хэмжсэн цацрагийн тунгийн чадал, Цөмийн хэмжүүрийн эргэн тойронд гадаргуугийн цацрагийн тунгийн чадал;
- Эцсийн хэрэглэгч байгууллагын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл;

3.16 Зөөврийн цөмийн хэмжүүрийг нийлүүлэгчээс илгээхийн өмнө эрх бүхий холбогдох хяналтын байгууллагад дараах мэдээллийг гаргаж өгнө. Үүнд:

- Хүлээн авагчийн нэр, хаяг;
- Цөмийн хэмжүүр бүр дээр үйлдвэрлэгчийн нэр, загвар, хувийн дугаар, үйлдвэрлэсэн огноог бичих;
- Цацрагийн үүсгүүрийн хэмжилт туршилтын гэрчилгээ.
- Цөмийн хэмжүүрийн үйл ажиллагаанд тохирсон цацрагийн аюулгүй ажиллагааг хангах хяналтын систем хаалт, цоож, түгжээний мэдээлэл
- Цацрагийн үүсгүүрийн хамгаалалтын савны мэдээлэл, цацрагийн хэмжилтийн дүн;

Дөрөв. Цацрагийн хамгаалалтын хөтөлбөр

4.1 Цацрагийн хамгаалалтын загвар хөтөлбөрт дараах шаардлагуудыг тусгасан байна. Үүнд:

- Хөтөлбөрт тусгах заалтууд:
 - Цөмийн хэмжүүр, цацрагийн үүсгүүрийн ашиглалт, зориулалт;
 - Үүрэг хариуцлага;
 - Цацрагийн хяналт, мониторинг;
 - Ажлын байрны хяналт;
 - Хувийн тунгийн хяналт;
 - Хувийн хамгаалах хэрэгсэл;
 - Цөмийн хэмжүүрийн ашиглалт, хадгалалт;
 - Цөмийн хэмжүүрийн тээвэрлэлт;
 - Цөмийн хэмжүүрт засвар үйлчилгээ хийх, түүнийг баримтжуулах;
 - Цөмийн хэмжүүрийг шилжүүлэх, ашиглалтаас гаргах;

- Цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагаа;
- Дотоод хяналт, шалгалт;
- Ослын бэлэн байдал;
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө;
- Бусад;

4.2 Цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг эрх бүхий холбогдох хяналтын байгууллага эсвэл цөмийн болон цацрагийн хяналтын улсын байцаагчаар хянуулан баталгаажуулна.

4.3 Зөөврийн цөмийн хэмжүүрийг нийлүүлэгч, түүний ажилтан, албан хаагчид нь энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллана.

Тав. Зөөврийн цөмийн хэмжүүрт тавигдах ерөнхий шаардлагууд

5.1 Цөмийн хэмжүүр нь дараах шаардлагыг хангасан байхаар зохион бүтээгдэнэ.

5.1.1 Цөмийн хэмжүүрийн цацрагийн үүсгүүр, үүсгүүрийн хамгаалалт, электроникийн эд ангиуд нь нэг гэрт байрласан цогц хийцтэй байна.

5.1.2 Цөмийн хэмжүүрийн ашиглалт, тээвэрлэлт, хадгалалтын хэвийн ажиллагааны үед цацрагийн үүсгүүр, түүнийг агуулах гэр нь цөмийн хэмжүүрийн хамгаалалтын гэрээс салахааргүй хийцтэй байна.

5.1.3 Цөмийн хэмжүүрт агуулагдах цацрагийн үүсгүүрийг гээгдэх, алдагдахаас сэргийлж, цацрагийн үүсгүүрийг гэрт хөдөлгөөнгүй бэхэлсэн байна.

5.1.4 Цөмийн хэмжүүр нь цацрагийн үүсгүүр, түүний гэр, хамгаалалтыг зэврэлт, тоос шороо, дулаан, чичирхийлэл, чийг зэрэг гаднын хүчин зүйлээс хамгаалсан байхаар хийцтэй байна.

5.1.5 Цацрагийн үүсгүүрийн гэр болон буцаан байрлуулах систем нь гацалт болон гэмтлээс сэргийлсэн байхаар хийцтэй байна.

5.1.6 Цацрагийн үүсгүүр бүхий гэр нь хамгаалалтын гэр дотор байрлалд байрлан түгжээгээр хамгаалагдах боломжтой байна.

5.1.7 Цацрагийн үүсгүүр бүхий гэр нь хамгаалалтын гэр дотор эсвэл ажлын горимын байрлалд байрлах боломжтой байна.

5.1.8 Цацрагийн үүсгүүрийн материал болон түүний хамгаалалтын гэрийн материалын физик химийн төлөв байдал нь цацрагийн шарлагын нөхцөлд тохирсон тэсвэртэй байна.

5.1.9 Зөөврийн цөмийн хэмжүүрийн гадна гадаргад дараах санамж, тэмдгүүдийг байрлуулсан байна. Үүнд:

- Цацрагийн аюулын анхааруулах тэмдэг;
- Цацраг идэвхт изотоп буюу цөмийн нэр;
- Цацраг идэвхт изотопын идэвх, хэмжигдсэн огноо;
- Цацрагийн үүсгүүр хамгаалалтын гэр дотор байрлах үед гадаргуу дээрх цацрагийн тунгийн чадлын хамгийн их хэмжээ;
- Цөмийн хэмжүүрийн үйлдвэрлэгчийн нэр, хаяг;
- Цөмийн хэмжүүр ба цацрагийн үүсгүүрийн хувийн дугаар;
- Хяналтын байгууллагын шаардсан бусад мэдээлэл;

5.1.10 Тээвэрлэлтийн хайрцаг дээр дээрх анхааруулах санамж тэмдгүүдийг тод гаргацтай байрлуулна.

5.2 Зөөврийн цөмийн хэмжүүрт ашиглагдах цацраг идэвхт материалыг сонгохдоо дараах шаардлагыг хангана.

5.2.1 Зөөврийн цөмийн хэмжүүрийн хэрэглээний нөхцөлд цацраг идэвхт материалын идэвх, цацрагийн төрөл, энерги, хагас задралын үе нь тохирсон байна.

5.2.2 Зөөврийн хэмжүүрийн ашиглалтын хугацаанд химийн болон физикийн төлөв нь тохирсон байна. Үүнд:

- Зэврэлт болон дотоод даралт үүсэхээс хамгаалагдсан байх;
- Үүсгүүрийн капсул гэмтсэн үед цацраг идэвхт материалын тархалт болон уусалт хамгийн бага байх;

5.2.3 Цацраг идэвхт үүсгүүрт дараах шаардлагыг хангавал зохино. Үүнд:

- Битүү хатуу байх;
- Амархан танигдах, тэмдэг тэмдэглэгээ, бичиг баримттай байх;
- Загвар, үйлдвэрлэгч, тэмдэг тэмдэглэгээ нь олон улсын стандартын шаардлагыг хангасан байх;
- Цацрагийн үүсгүүрийн дагалдах бичиг баримтууд нь үйлдвэрлэсэн улс, үйлдвэрлэгч байгууллагын нэр, үүсгүүрийн гэрчилгээ, идэвх, химийн болон физикийн төлөв байдал, сери дугаар, үйлдвэрлэгдсэн огноо, цацрагийн аюулгүй ажиллагааны заавар, туршилт хэмжилтийн гэрчилгээ зэргийг агуулсан байх;

5.2.4 Цацрагийн үүсгүүр хадгалах байрны түлхүүр ашиглалтын талаар тусгай дэвтэрт бүртгэл хөтөлнө.

5.2.5 Хөдөө хээр газар зөөврийн цөмийн хэмжүүр гэмтэх, хулгайд алдагдах, галд өртөх зэрэг аюул ослын тохиолдолд холбоо барьж тусламж үзүүлэх ба холбогдох хяналтын байгууллагуудад шуурхай мэдэгдэнэ.

5.2.6 Холбогдох эрх бүхий байгууллагаар хянуулж, баталгаажуулсан цацрагийн аюулгүй ажиллагааны дотоод дүрмийг бүх операторуудад судлуулж, мөрдүүлэх арга хэмжээ авах, хэрэгжилтийг тогтмол шалгаж, зөрчлийг арилгуулна.

5.2.7 Цацрагийн үүсгүүр нь хамгаалалтын гэр дотор байрлалд байх үед цацрагийн тунгийн чадал дараах утгаас хэтрэхээргүй байхаар хамгаалалтын гэртэй байна. Үүнд:

- Зөөврийн цөмийн хэмжүүрийн гадаргуугаас 5 см зайд цацрагийн тунгийн чадал 250мкЗв/цагаас хэтрэхгүй байх;
- Зөөврийн цөмийн хэмжүүрийн гадаргуугаас 1м зайд цацрагийн тунгийн чадал 10мкЗв/цагаас хэтрэхгүй байх;

5.2.8 Хамгаалалтын гэр нь зөөврийн цөмийн хэмжүүрийн ашиглалт, хадгалалт, тээвэрлэлтийн хэвийн ажиллагааны үед доргилт, чичирхийлэл зэргээс шалтгаалан хамгаалалтын цогц байдлаа алдахааргүй хийцтэй байна.

Зургаа. Цацрагийн аюулгүй ажиллагаа

6.1 Цацрагийн үүсгүүр бүхий зөөврийн цөмийн хэмжүүрийг ашиглан, зам талбай дээр хэмжилт хийх цацрагийн ажилтан нь цөмийн хэмжүүрийг ажиллуулах дадлага эзэмшсэн, цацрагийн аюулгүйн сургалтад хамрагдсан гэрчилгээтэй байх шаардлагатай.

6.2 Зөөврийн цөмийн хэмжүүрийг хараа хяналтгүй орхих буюу зөвшөөрөлгүйгээр бусдад шилжүүлэхийг хориглоно.

6.3 Ажлын талбайд зөөврийн цөмийн хэмжүүр ашиглах явцад цацрагийн ажилтан, түүний туслах ажилтнууд нь хувийн дозиметр зүүсэн байна.

6.4 Зөөврийн цөмийн хэмжүүрийг орон нутагт шилжүүлэн хэрэглэхэд эрх бүхий холбогдох хяналтын болон бусад байгууллагуудад мэдэгдэнэ.

6.5 Зөөврийн цөмийн хэмжүүрийг зам, талбайд ашиглаж байх тохиолдолд цацрагийн ажилтан нь аюулгүй байдлыг хангах зорилгоор ажлын аюулгүйн бүсийг тогтоож, тод өнгийн туузаар тойруулан хил тогтоож, цацрагийн аюулын тэмдэг, санамжийг байрлуулж, тээврийн хэрэгсэл, хүн зөвшөөрөлгүй нэвтрүүлэхгүй байх нөхцөлийг бүрдүүлнэ. Хил тогтооход ашиглах тууз, анхааруулах санамж тэмдэг зэрэг холбогдох материалаар хангагдсан байвал зохино.

6.6 Зөөврийн цөмийн хэмжүүр цацрагийн ажилтны мэдэлд байх үед дараах бичиг баримтыг хамт авч явна. Үүнд:

- Цацрагийн болзошгүй осол болон хэвийн бус нөхцөл үүссэн үед ажиллах заавартай цацрагийн аюулгүй ажиллагааны дүрэм;
- Хяналтын байгууллагаас олгосон “Цацрагийн үүсгүүр ашиглах, хадгалах, тээвэрлэх эрхийн тусгай зөвшөөрөл”-ийн хуулбар;
- Ажиллуулж буй зөөврийн цөмийн хэмжүүрийн цацрагийн үүсгүүрийн үйлдвэрийн гэрчилгээний хуулбар эдгээр болно.

6.7 Зөөврийн цөмийн хэмжүүрийг хэрэглэж дууссаны дараа хадгалах байранд буцаан хийхийн өмнө, цацрагийн ажилтан эсвэл цацрагийн аюулгүй байдал хариуцсан ажилтан цацрагийн хэмжилт хийж, тэмдэглэл хөтөлнө.

6.8 Цацрагийн ажилтан нь зөөврийн цөмийн хэмжүүрийн гэмтэл, цацрагийн осол, шарлагад өртөх, аливаа хэвийн бус нөхцөл байдал үүсэх тохиолдолд байгууллагын Цацрагийн хяналтын ажилтанд болон удирдлагад нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.

6.9 Холбогдох бусад нийтлэг дүрэмд заасан шаардлагуудыг биелүүлнэ.

Долоо. Хадгалах, тээвэрлэх, булшлах

7.1 Зөөврийн цөмийн хэмжүүрийг хадгалах

7.1.1 Зөөврийн цөмийн хэмжүүрийг хадгалалтад дараах шаардлагыг хангана. Үүнд:

- Цацрагийн хамгаалалт, аюулгүй байдал бүрэн хангагдсан хадгалах байртай байх;
- Түгжээтэй, харуул хамгаалалттай байх;
- Зөөврийн цөмийн хэмжүүрийг тэсэрч дэлбэрэх болон шатамхай бодис, шахсан болон шингэрүүлсэн хий, идэмхий бодис гэх мэт химийн бодистой хамт хадгалахыг хориглох;
- Зөөврийн цөмийн хэмжүүрийг түр хадгалахдаа эрх бүхий холбогдох хяналтын байгууллагын холбогдох цөмийн болон цацрагийн хяналтын улсын байцаагч болон ханган нийлүүлэгчтэй холбоо барих мэдээллийг хавсаргаж хадгалах;
- Анхааруулах тэмдэг, зааврыг байрлуулсан байх;

7.1.1 Нягт, чийг хэмжих зориулалтын зөөврийн цөмийн хэмжүүрийг хадгалахдаа дараах шаардлагыг хангана. Үүнд:

- Зөөврийн цөмийн хэмжүүрийг хадгалах байрны гадаах цацрагийн тунгийн чадал нь 10 мкЗв/цаг- аас хэтрэхгүй байх буюу холбогдох норм, дүрэм, журамд өгсөн зөвлөмжид зааснаас хэтрэхгүй байх;
- Хүн амын авах тун жилд 1мЗв-ээс хэтрэхгүй байх;

7.1.2 Холбогдох эрх бүхий байгууллагын зөвшөөрөлтэйгөөр цөмийн болон цацрагийн хяналтын улсын байцаагчийн хяналтад хадгалах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

7.1.3 Хадгалах байр нь дараах шаардлагуудыг хангасан байвал зохино. Үүнд:

- “Анхаар цацраг идэвх” гэсэн анхааруулга тэмдэгтэй байх;
- Цацрагийн үүсгүүр байхгүй үед ч байнга цоожтой байлгах;
- Цоож, лац гэмтсэн, цацрагийн үүсгүүр хулгайд алдагдсан тохиолдолд цацрагийн хяналтын ажилтан, холбогдох эрх бүхий орон нутгийн тагнуул, цагдаагийн байгууллага, онцгой байдлын болон хяналтын байгууллагад яаралтай мэдэгдэх;
- Гал унтраах хэрэгсэл болон гал түймрийн дохиоллын системээр тоноглогдсон ба мөн агааржуулалтын системтэй байх;
- Монгол Улсын стандарт “MNS 6240:2011 Цацраг идэвхт материалын сав баглаа боодол. Техникийн ерөнхий шаардлага”-ыг дагаж мөрдөнө. Цацрагийн үүсгүүрийг хадгалахдаа шар дэвсгэр дээр хар тэмдэг бүхий цацрагийн анхааруулах шошгыг наах; Шошго нь цацрагийн аюулыг анхааруулах тэмдэгтэй байх бөгөөд “Анхаар! Цацраг идэвх” гэсэн эсвэл үүнтэй нэгэн ижил утгатай санамж байрлуулсан байх;
- Цацрагийн үүсгүүр хулгайд алдагдахаас урьдчилан сэргийлэгдсэн, зөвшөөрөлгүй этгээд авч ашиглахаас хамгаалагдсан байх
- Хадгалах байрны хаалгыг цоожлон лацдаж, харуул, жижүүрүүдэд хүлээлгэн өгч байх;
- Өөр байгууллага, аж ахуйн нэгжийн эзэмшлийн байранд хадгалах бол эрх бүхий холбогдох хяналтын байгууллагад мэдэгдэж, эрх бүхий улсын байцаагч зөвшөөрвөл бичгээр гэрээ байгуулж, үүсгүүр хадгалж буй байршлыг холбогдох байгууллагад мэдэгдэнэ.

7.2 Зөөврийн цөмийн хэмжүүрийг тээвэрлэх

7.2.1 Иргэн, аж ахуйн нэгж байгууллага нь зөөврийн цөмийн хэмжүүрийг тээвэрлэхдээ “Цацраг идэвхт материалыг аюулгүй тээвэрлэх дүрэм”, “Автотээврийн

хэрэгслээр хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд аюул хохирол учруулж болзошгүй ачаа тээвэрлэх журам”, “Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага /MNS 4598:2011/”, “Аюултай ачаа ангилал. Техникийн ерөнхий шаардлага /MNS 4978:2000/” болон бусад холбогдох дүрэм, журам, стандартад тавигдсан шаардлагыг чанд мөрдөнө.

7.2.2 Зөөврийн цөмийн хэмжүүрийг тээвэрлэх үед тээвэрлэлтийн хаяг, шошго, цацрагийн аюулгүйн тэмдэг анхааруулга тэмдэг хэрэглэж байгаа эсэх, аюулгүй тээвэрлэх дүрмийн шаардлагыг хэрхэн биелүүлж байгаа байдалд хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээг авна.

7.2.3 Зөөврийн цөмийн хэмжүүрийн тээвэрлэлтийн явцад зохих шошго, тэмдэглэгээ бүхий зориулалтын тээвэрлэх хайрцагт хийж цоожлон тээвэрлэнэ.

7.2.4 Зөөврийн цөмийн хэмжүүрийг тээврийн хэрэгсэл байрлуулахдаа хүмүүсээс аль болох хол, тунгийн чадал бага байхаар (үүнийг хэмжилт хийж тодорхойлно) бат найдвартай, хөдөлгөөнгүй бэхлэнэ.

7.2.5 Тээвэрлэх үйл ажиллагааг эхлэхээс өмнө эрх бүхий холбогдох хяналтын байгууллага болон цөмийн болон цацрагийн хяналтын ажилтанд мэдэгдэнэ.

7.2.6 Цацраг идэвхт ачааг автотээврийн техникийн үзлэгт орж тэнцсэн тээврийн хэрэгслээр зөвхөн тээвэрлэнэ.

7.2.7 Цацраг идэвхт ачааг бусад төрлийн аюултай ачаа /тэсэрч дэлбэрэх болон шатамхай бодис, шахсан болон шингэрүүлсэн хий, идэмхий бодис гэх мэт/, асарч норгох шингэн материал болон ослын үед цацраг идэвхт ачааны бүрэн бүтэн байдлыг эвдэж болох зүйлүүдтэй хамт тээвэрлэхийг хориглоно.

7.2.8 Тээвэрлэлтийн хайрцаг савыг заавал цоожтой байлгах ба зөөврийн цөмийн хэмжүүрийг хариуцаж буй ажилтан уг автомашиныг орхиж явах, түр гарах үед автомашиныг байнга цоожилно.

7.2.9 Задгай автомашинд тээвэрлэх бол хайрцаг сав баглаа боодлыг түгжиж сайтар бэхлэх ба зөөврийн цөмийн хэмжүүрийг хариуцаж буй ажилтан нь хамт харгалзан явна.

7.2.10 Цацраг идэвхт ачааг тээвэрлэх тээврийн хэрэгслийн хойд тал, 2 хажуу талд цацрагийн аюулын анхааруулах тэмдэг тавьж, хөдөлгөөнд оролцож буй бусад тээврийн хэрэгслийн жолооч нарт харагдахуйцаар байрлуулна. Цацрагийн үүсгүүр тээвэрлээгүй үед цацрагийн анхааруулах тэмдгийг салган авч байх шаардлагатай. Хэмжээ нь 250 мм х 250 мм байна.



Зураг 1. Тээврийн хэрэгсэл болон контейнер болон сав боодол дээр байрлуулах анхааруулах тэмдэг



Зураг 2. Тээвэрлэлтийн хайрцаг дээр байрлуулах II зэрэглэлийн шошго

Тайлбар: Зураг 1-т үзүүлсэн зурагт тэмдгийн дээд тал нь шар, доод тал нь цагаан өнгөтэй, цацрагийн тэмдэг нь хар өнгөөр бичигдсэн байна. “Цацраг идэвхт” гэсэн үг нь доод талын хэсэгт Нэгдсэн үндэсний байгууллага (НҮБ)-аас гаргасан зөвлөмжийн дугаарын дээд талд хараар бичигдэнэ.

Тайлбар: Зураг 2-т үзүүлсэн II-Шар зэрэглэлийн шошгоны дээд тал нь шар, доод тал нь цагаан өнгөтэй дэвсгэр дээр цацрагийн тэмдэг болон бичиглэл нь хар өнгөтэй байх ба зэрэглэлийг улаанаар бичнэ.

7.2.11 Хэрэв тэвштэй машинаар тээвэрлэх хугацаанд зочид буудалд хоноглох тохиолдолд хайрцаг савыг найдвартай цоожилж бүтээх ба тээврийн хэрэгслийн кабинд оруулж цоожилно.

7.2.12 Зөөврийн цөмийн хэмжүүр тээвэрлэж яваа жолооч нь Цацрагийн үүсгүүрийг ашиглах буюу харгалзан яваа цацрагийн ажилтан/жолооч, цацрагийн ажилтан хоёулаа хувийн дозиметр зүүсэн байна/-оос өөр зорчигч тээвэрлэхийг хориглоно.

7.2.13 Цацраг идэвхт ачаа тээвэрлэж буй жолооч нь “Аюултай ачаа тээвэрлэх дүрэм”, цацрагийн аюулгүй ажиллагааны дотоод дүрэм, ослын үед авах арга хэмжээний төлөвлөгөөтэй танилцаж, гарын үсэг зурж баталгаажуулна.

7.2.14 Жолооч, ажилтны суудлын орчинд цацрагийн тунгийн чадал 10 мкЗв/цагаас хэтрэхгүй байвал зохино. Үүнийг цацрагийн хэмжилтээр тогтооно.

7.2.15 Цацраг идэвхт ачаа тээвэрлэж буй жолооч нь тээврийн хэрэгсэл жолоодох бичиг баримтаас гадна цацраг идэвхт үүсгүүр тээвэрлэх зөвшөөрөл, замын маршрут, үүсгүүрийн холбогдох бичиг баримтууд, “Аюултай ачаа тээвэрлэх дүрэм”, цацрагийн аюулгүй ажиллагааны дотоод дүрэм, ослын үед авах арга хэмжээний төлөвлөгөөний хуулбарыг авч явна.

7.2.16 Цацрагийн үүсгүүр тээвэрлэх тээврийн хэрэгсэл нь гал унтраах хэрэгсэл, ослын дохионы гурвалжин, бусад хэрэгслүүдээр хангагдсан байх шаардлагатай. Үүнд: эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх хэрэгсэл, ариутгалын спирт, иодын уусмал гэх мэт.

7.2.17 Цацраг идэвхт ачаа тээвэрлэж яваа жолооч нь “Автотээврийн хэрэгслээр хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд аюул хохирол учруулж болзошгүй ачаа тээвэрлэх журам”-д заасан хурдтай явж, ачааны байдлыг шалган, зөрчил илэрвэл арилгах арга хэмжээ авна.

7.2.18 Үзэгдэх орчин хязгаарлагдсан үед зогсолт хийх бол цацрагийн үүсгүүр тээвэрлэж буй автомашины ослын болон анхааруулах гэрэл дохиог асаана.

7.2.19 Цацрагийн үүсгүүр тээвэрлэж буй тээврийн хэрэгслээр маршрутын бус газар, ажлын шаардлагагүй газраар явахыг хатуу хориглоно.

7.2.20 Цацраг идэвхт ачаа буулгасны дараа Цацрагийн хяналтын ажилтан эсвэл зөөврийн цөмийн хэмжүүрийг хариуцаж буй ажилтан нь тээврийн хэрэгсэлд цацрагийн хэмжилт хийж, замын хуудсанд тэмдэглэнэ.

7.2.21 Цацраг идэвхт ачаа бүхий автомашиныг хүн ам ихтэй газарт удаан зогсохыг хориглох бөгөөд шатахуун түгээгүүрийн газарт дараалал харгалзахгүй үйлчлүүлнэ.

7.2.22 Ашиглахаас бусад үед зөөврийн цөмийн хэмжүүрийн тээвэрлэлтийн хайрцаг, тээвэрлэж яваа тээврийн хэрэгслийг ямагт цоожилж байна.

7.3 Зөөврийн цөмийн хэмжүүрийн булшлалт

7.3.1 Зөвшөөрөл эзэмшигч нь цөмийн хэмжүүр, цацрагийн үүсгүүрийг гээгдүүлэх, үрэгдүүлэх, булшлахыг хатуу хориглоно.

7.3.2 Зөөврийн цөмийн хэмжүүрийг ашиглалтаас гаргасны дараа гэрээнд заагдсаны дагуу үйлдвэрлэгчид буцаах эсвэл

7.3.3 Цацрагийн үүсгүүрийн төвлөрүүлэн хадгалах болон цацраг идэвхт хаягдлын менежментийн байгууламжийн байнгын хадгалалтад шилжүүлнэ.

Найм. Засвар үйлчилгээ

8.1 Үйлдвэрлэгчийн зааврын дагуу аюулгүй ажиллагааны цэвэрлэгээ хийнэ. Зөөврийн цөмийн хэмжүүрийг цэвэрлэх ажлыг аюулгүй цэвэрлэх, зааварчилгаа авсан цацрагийн ажилтан болон түүний туслах гүйцэтгэх бөгөөд цэвэрлэгээний явцад хувийн дозиметр зүүнэ.

8.2 Цэвэрлэгээнд ашиглах толь, цэвэрлэгээний материал, спирт, сойз, зэргийг урьдчилан бэлтгэсэн байвал зохино.

8.3 Засвар үйлчилгээ хийхдээ зөөврийн цөмийн хэмжүүрээс цацрагийн үүсгүүрийг салгахыг хориглоно.

8.4 Зөөврийн хайрцаг савыг тогтмол шалгаж, бүх хаяг, шошго, заавар дүрмийг уншиж болох эсэхийг магадлан шалгаж байх шаардлагатай.

8.5 Засвар үйлчилгээг хийхдээ зөөврийн цөмийн хэмжүүрийн үйлдвэрлэгчийн заавар, зөвлөмжийг дагаж мөрдөнө.

Ес. Болзошгүй цацрагийн ослын үед авах арга хэмжээний төлөвлөлт, бэлэн байдал

9.1 Зөөврийн цөмийн хэмжүүрийг хадгалж буй байранд гал түймэр гарсан үед дараах арга хэмжээг авна. Үүнд:

- Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагатай холбогдож шуурхай мэдээлэх;
- Хайрцаг сав эвдэрч шатсан бол хөдөлгөхгүй байх;
- Хайрцаг сав нь бүтэн бол гал гарч буй бүсээс зөөврийн цөмийн хэмжүүрийг гаргаж холдуулах;
- Тууз ашиглан ослын бүсэд цацрагийн хэмжилт хийн тогтоож, харуул хамгаалалтад авах;
- Эрх бүхий холбогдох хяналтын байгууллагад мэдээлэх;
- Гал сөнөөгчдөд цацраг идэвхт материалын байршил, хор хөнөөлийн талаар мэдэгдэх, заавар зөвлөгөө өгөх, шаардлагатай хувцас хэрэгсэл, хувийн дозиметрээр хангах;
- Тухайн нөхцөлд ажилласан гал сөнөөгч, аврагчдын тунгийн болон эрүүл мэндийн эрсдэлийн мэдээллийг танилцуулж, эмнэлгийн үзлэгт хамруулан, мэргэжлийн шарлагын хувийн тунгийн хяналтад хамруулах;

9.2 Тээвэрлэж явсан автомашин авто тээврийн осолд орсон бол цацрагийн үүсгүүр бүхий зөөврийн цөмийн хэмжүүрийн хайрцаг, цөмийн хэмжүүр гэмтээгүй тохиолдолд цөмийн хэмжүүрийг хараа хяналтад байлган, холбогдох албадад мэдэгдэнэ. Тээвэрлэх хайрцаг болон цөмийн хэмжүүр эвдэрч гэмтсэн үед дараах зааврын дагуу ажиллана. Үүнд:

- Зөөврийн цөмийн хэмжүүрийг тухайн газар хөдөлгөөнгүй байрлуулах;
- Зөөврийн цөмийн хэмжүүрт хүрэх, хөдөлгөхийг хориглох;
- Зөөврийн цөмийн хэмжүүрийн ойролцоох газрыг нэн даруй 5-10 м голчтой тойргоор тусгаарлан, уг газрыг харуул хамгаалалтад авч, анхааруулах тэмдэг байрлуулах;
- Тусгай албаны хүмүүсийн зөвшөөрөлгүйгээр цөмийн хэмжүүрт ойртохыг бүх хүмүүст хориглох;
- Хэрэв машинаар тээвэрлэж явсан тохиолдолд ямар нэг хэмжээгээр цацрагийн алдагдал гарч байгаа нь тогтоогдвол тээврийн хэрэгслийг нэн даруй зогсоож холбогдох арга хэмжээг авах;
- Цацрагийн хэмжилт хийхдээ цөмийн хэмжүүрээс 1м-ийн зайд хийх;

9.3 Цацрагийн болон аливаа аюул осол, зөвшөөрөлгүй этгээд ашигласан, цацрагийн үүсгүүрээс шарлага авах нөхцөл байдал үүссэн тохиолдол бүрт эрх бүхий холбогдох хяналтын байгууллагатай яаралтай холбоо барьж, дараах мэдээллийг өгнө. Үүнд:

- Аюул осол гарсан он, сар, өдөр, байршил;
- Зөөврийн цөмийн хэмжүүрийн загвар, хувийн дугаар;
- Аюул ослын нөхцөл байдал;
- Зөөврийн цөмийн хэмжүүрээс 1 м-ийн зайд цацрагийн тунгийн чадал;

- Бохирдол үүссэн эсэх;
- Ажилтан шарлагад өртсөн эсэх;

9.4 Хулгайд алдагдах ба хаяж үрэгдүүлсэн тохиолдолд цацрагийн хяналтын болон цагдаа, тагнуулын албанд яаралтай мэдэгдэнэ.

9.5 Цацрагийн осол, хэвийн бус нөхцөл үүсэх болон аюул ослын үед холбоо барих утасны жагсаалад дараах байгууллагатай холбоо барих холбогдох албан хаагч болон байгууллагын утсыг тэмдэглэсэн байна.

- Хяналтын байгууллага;
- Цөмийн энергийн асуудал эрхэлсэн байгууллага;
- Тагнуулын байгууллага;
- Цагдаагийн байгууллага;
- Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллага;

9.6 Орон нутагт ажиллах тохиолдолд тухайн орон нутгийн холбогдох албадын утасны жагсаалтыг ослын төлөвлөгөөнд хавсаргана.

- Орон нутгийн Цагдаагийн алба;
- Орон нутгийн Тагнуулын алба;
- Орон нутгийн Онцгой байдлын алба;

Арав. Дотоод хяналт, мониторинг

10.1 Энэхүү дүрэмд дагаж мөрдөх цацрагийн дотоод хяналт, мониторинг Цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааны үндсэн дүрмийн шаардлагуудад заасан арга хэмжээг авна.

xxxXXxxx

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

[1] МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ, Цөмийн энергийн тухай хууль (2015 оны 02 дугаар сарын 13- ны өдөр нэмэлт өөрчлөлт орсон хувилбар) Монгол улс, Улаанбаатар хот (2009.07.16) <http://www.legalinfo.mn/law/details/97?lawid=97>

[2] Цацрагийн аюулгүйн норм, Цөмийн энергийн комиссын 2015 оны 07 дугаар сарын 28-ны өдрийн 06 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт, Улаанбаатар хот (2015) <http://www.nea.gov.mn/uploads/news/attachment/17e1e0296e1936cc0594f6e95d3c7538588f5aca.pdf>

[3] Цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааны үндсэн дүрэм, Цөмийн энергийн комиссын 2016 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн 01 дүгээр тогтоолын хавсралт Улаанбаатар хот (2016)

[4] Цацрагтай холбогдолтой үйл ажиллагаа эрхэлж буй байгууллагын цацрагийн аюулгүйн албаны дүрэм Цөмийн энергийн комиссын 2015 оны 07 дугаар сарын 28-ны өдрийн 06 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт, Монгол улс, Улаанбаатар хот (2015) <http://www.nea.gov.mn/uploads/news/attachment/17e1e0296e1936cc0594f6e95d3c7538588f5aca.pdf>

[6] Авто замын салбарт цөмийн хэмжүүр ашиглахад дагаж мөрдөх цацрагийн аюулгүй ажиллагааны дүрэм, Монгол улс, Улаанбаатар хот (2010) <http://www.nea.gov.mn>

[7] Цацрагийн үүсгүүртэй холбоотой үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох журам (2015)

[8] INTERNATIONAL ATOMIC ENERGY AGENCY, Categorization of Radioactive Sources, IAEA Safety Standards for protecting people and the environment, Safety Guide No.RS-G-1.9, Vienna (2005) http://www-pub.iaea.org/MTCD/publications/PDF/Pub1227_web.pdf

[9] INTERNATIONAL ATOMIC ENERGY AGENCY, Identification of Radioactive Sources and Devices, IAEA Nuclear Security Series No.5, Technical Guidance-Reference Manual, IAEA, Vienna (2007) http://www-pub.iaea.org/MTCD/publications/PDF/Pub1278_web.pdf

[10] INTERNATIONAL ATOMIC ENERGY AGENCY, Combating Illicit Trafficking in Nuclear and other Radioactive Material, IAEA Nuclear Security Series No.6, Technical Guidance- Reference Manual, IAEA, Vienna (2007) http://www-pub.iaea.org/MTCD/Publications/PDF/pub1309_web.pdf

[11] INTERNATIONAL ATOMIC ENERGY AGENCY, Regulations for the Safe Transport of Radioactive Material, IAEA Safety Standards for protecting people and the environment, Specific Safety Requirements No.SSR-6, IAEA, Vienna (2012) http://www-pub.iaea.org/MTCD/publications/PDF/Pub1570_web.pdf

[12] Code of practice and Safety guide, Portable Density/Moisture Gauges Containing Radioactive Sources, Radiation Protection Series Publication No. 5, Australia, Victoria (May 2004) <http://www.arpansa.gov.au/pubs/rps/rps5.pdf>

[13] HEALTH AND SAFETY EXECUTIVE OF NEW ZEALAND. TG-3 Use of Nuclear Density Meters, CETA New Zealand, Technical Guideline (TG) (December 2014) http://www.cetanz.org.nz/Publications/TG3_Use_of_Nuclear_Density_Meters.pdf

[14] Guidelines for Use of Nuclear Moisture/Density Gauges, Western Australia (April

2005)

http://www.uwa.edu.au/data/assets/pdf_file/0010/1723996/Nuclear_Moisture_Density_Gauges.pdf

[15] Portable nuclear moisture/density gauges in the construction industry, Ionizing Radiation Information Sheet No.3, Health and Safety Executive, HEALTH AND SAFETY EXECUTIVE OF NEW ZEALAND, HSE information sheet (February 2008)

<http://www.hse.gov.uk/pubns/iris3.pdf>

[16] Vicroads, Surveillance of Field Density Testing by Nuclear Density Gauge, Technical note 106 (September 2014)

https://www.google.mn/?gws_rd=cr,ssl&ei=xlMaVYvzOtK0oQT_3oHoAQ#q=surveillanc+of+field+nuclear+gauge

[17] THE UNIVERSITY OF MELBOURNE, Radiation Safety, Portable Density/Moisture Gauge- Radiation Management Plan (October 2013)

http://safety.unimelb.edu.au/docs/Portable_Density_Moisture_Gauge_Management_Plan.pdf

[18] <http://www.humboldtscientific.com/>

[19] Монгол улсын стандарт, Цацраг идэвхт сав баглаа боодол, Техникийн ерөнхий шаардлага, MNS 6240:2011, Албан хэвлэл, Монгол улс, Улаанбаатар хот (2011)

xxxXXXxxx